

Улаанбаатар хотын агаарын чанарын төлөв байдал
(Хүйтний улирал буюу 2019 оны 10-12, 2020 оны 1-4 дүгээр сар)

Улаанбаатар хотын агаарын чанарыг гэр хороолол, автозам, орон сууцны хороолол, үйлдвэрийн дүүрэг орчмын 15 цэгт агаар бохирдуулах бодис болох хүхэрлэг хий (SO₂), азотын давхар исэл (NO₂), PM2.5, PM10 тоосонцор, нүүрстөрөгчийн дутуу исэл (CO), озон (O₃) болон цаг уурын үзүүлэлтүүдийг автомат багажаар болон химийн аргаар тодорхойлдог.


2019-2020 оны хүйтний улирал буюу 2019 оны 10-12, 2020 оны 1-4 дүгээр сарын Улаанбаатар хотын агаар дахь агаар бохирдуулах бодисын дундаж агууламжийг өмнөх оны мөн үеийн дундаж агууламжтай харьцуулахад PM2.5 тоосонцор 43мкг/м³-ээр буюу 40%, PM10 тоосонцор 72мкг/м³-ээр буюу 39%-аар тус тус бага, хүхэрлэг хий 29мкг/м³-ээр буюу 80%-аар их, азотын давхар исэл 9мкг/м³-ээр буюу 21%-аар их байлаа.

Бохирдуулах бодисын нэр	Агаарын чанарын стандарт MNS 4585:2016	Дундаж агууламж, мкг/м ³	
	Хүлцэх агууламж, мкг/м ³	2018 оны 10-12-р сар, 2019 оны 1-4-р сарын дундаж	2019 оны 10-12-р сар, 2020 оны 1-4-р сарын дундаж
PM2.5 тоосонцор	50	107	64 (40%↓)
PM10 тоосонцор	100	184	112 (39%↓)
Хүхэрлэг хий, SO ₂	50	36	65 (80%↑)
Азотын давхар исэл, NO ₂	50	43	52 (21%↑)

Өмнөх онтой харьцуулахад * ↓ бага; ↑ их; ↔ ойролцоо түвшинд /±5%/.

Улаанбаатар хотын хүйтний улирлын гол бохирдуулах бодис тус бүрийн агууламжийг дараах хэсэгт харуулав.


PM2.5 тоосонцор



Зураг 1. Хүйтний улирлын PM2.5 тоосонцрын дундаж агууламж, 2016-2020 он

2019 оны 10-12, 2020 оны 1-4 дүгээр сарын агаар дахь PM2.5 тоосонцрын дундаж агууламж 2015-2016 оноос 34%, 2016-2017 оноос 51%, 2017-2018 оноос 46%, 2018-2019 оноос 40%-иар тус тус бага байна.


Хүйтний улирлын PM2.5 тоосонцрын дундаж агууламжийг Агаарын чанарын стандарт дахь Хүлцэх агууламж /цаашид АЧС дахь ХА гэх/-тай харьцуулахад 2015-2016 онд 2 дахин, 2016-2017 онд 2.6 дахин, 2017-2018 онд 2.4 дахин, 2018-2019 онд 2.1 дахин, 2019-2020 онд 1.3 дахин тус тус их байна (Зураг 1).



Зураг 2. Хүйтний улирлын PM2.5 тоосонцрын сарын дундаж агууламж, 2016-2020 он

2019-2020 оны хүйтний улиралд агаар дахь PM2.5 тоосонцрын сарын дундаж хамгийн их агууламж 2019 оны 12 дүгээр сард ажиглагдаж 2018 оны мөн үетэй харьцуулахад 38%-иар бага, АЧС дахь ХА-тай харьцуулахад 2.3 дахин их байна (Зураг 2).


PM10 тоосонцор



Зураг 3. Хүйтний улирлын PM10 тоосонцрын дундаж агууламж, 2016-2020 он

2019 оны 10-12, 2020 оны 1-4 дүгээр сарын агаар дахь PM10 тоосонцрын дундаж агууламжийг өмнөх онуудын мөн үетэй харьцуулахад 2015-2016 онд 23%, 2016-2017 онд 34%, 2017-2018 онд 31%, 2018-2019 онд 39%-иар тус тус бага байна.


Сүүлийн 5 жилийн хүйтний улирлын PM10 тоосонцрын дундаж агууламжийг АЧС дахь ХА-тай харьцуулахад 2015-2016 онд 1.5 дахин, 2016-2017 онд 1.7 дахин, 2017-2018 онд 1.6 дахин, 2018-2019 онд 1.8 дахин, 2019-2020 онд 1.1 дахин их байна (Зураг 3).



Зураг 4. Хүйтний улирлын PM10 тоосонцрын сарын дундаж агууламж, 2016-2020 он

Энэ жилийн хүйтний улирлын PM10 тоосонцрын хамгийн их агууламж 2019 оны 12 дугаар сард ажиглагдсан бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 43%-иар бага, АЧС дахь ХА-тай харьцуулахад 1.4 дахин их байна (Зураг 4).


Хүхэрлэг хий (SO₂)



Зураг 5. Хүйтний улирлын хүхэрлэг хийн дундаж агууламж, 2016-2020 он

2019 оны 10-12, 2020 оны 1-4 дүгээр сарын хүхэрлэг хийн дундаж агууламжийг 2015-2016 онтой харьцуулахад 22%, 2016-2017 онтой харьцуулахад 47%, 2017-2018 онтой харьцуулахад 96%, 2018-2019 оны мөн үетэй харьцуулахад 81%-иар тус тус их байна.


Хүйтний улирлын хүхэрлэг хийн дундаж агууламжийг АЧС дахь ХА-тай харьцуулахад 2015-2016 онд 1.1 дахин их, 2019-2020 онд 1.3 дахин их байна (Зураг 5).



Зураг 6. Хүйтний улирлын хүхэрлэг хийн сарын дундаж агууламж, 2016-2020 он

2019-2020 оны хүйтний улиралд агаар дахь хүхэрлэг хийн хамгийн их агууламж 2020 оны 1 дүгээр сард ажиглагдсан бөгөөд 2019 оны мөн үетэй харьцуулахад 97%-иар их, АЧС дахь ХА-тай харьцуулахад 2.4 дахин их байна (Зураг 6).


Азотын давхар исэл (NO₂)



Зураг 7. Азотын давхар ислийн хүйтний улирлын дундаж агууламж, 2016-2020 он

2019 оны 10-12, 2020 оны 1-4 дүгээр сарын азотын давхар ислийн дундаж агууламж 2015-2016 оноос 28%, 2016-2017 оноос 9%, 2017-2018 оноос 16%, 2018-2019 оноос 22%-иар тус тус их байна.

Сүүлийн 5 жилийн хүйтний улирлын азотын давхар ислийн дундаж агууламжийг АЧС дахь ХА-тай харьцуулахад 2019-2020 онд 1.1 дахин их байна (Зураг 7).



Зураг 8. Хүйтний улирлын азотын давхар ислийн сарын дундаж агууламж, 2016-2020 он

2019-2020 оны хүйтний улирлын азотын давхар ислийн хамгийн их агууламж 2019 оны 12 дугаар сард ажиглагдаж, 2018 оны мөн үетэй харьцуулахад 27%-иар их, АЧС дахь ХА-тай харьцуулахад 1.3 дахин их байна (Зураг 8).

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС